

ДАГАЛДАН ВИЗ (F-3-1)

ОЛГОХ ХҮРЭЭ:

D-1, D-2, D-4, D-5, D-6, D-7, D-9, E-1~E-7 ангиллын оршин суух эрхтэй иргэний эхнэр/нөхөр ба насанд хүрээгүй, гэрлээгүй хүүхэд.

Дагалдан ангиллын визээр Монгол Улсаас БНСУ-д зорчихыг хүсч буй иргэн Солонгосын Виз Мэдүүлгийн Төвөөр дамжуулан виз мэдүүлнэ. Та нэг удаагийн, нэг жил хүртлэх виз мэдүүлэх боломжтой. Виз шалгагдах явцад БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтыг шаардах боломжтой.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Цагдаагийн газрын тодорхойлолт (18–аас дээш, 60-аас доош насны анх удаа зорчиж буй иргэнд хамаарна)
4. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт
 - Гэрлэлт бүртгэлийн лавлагаа, насанд хүрээгүй хүүхэдтэй тохиолдолд төрсний бүртгэлийн лавлагаа өгөх
5. Сүрьеэгийн шинжилгээний бичиг (БНСУ-ын ЭСЯ-аас заасан эмнэлэг)

УРИГЧ ТАЛЫН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Урилга (Эх хувь): Нотариатаар баталгаажуулсан урилга (Урих болсон шалтгаан, хууль бусаар хөдөлмөр эрхлэхгүй байх мөн эх орондоо буцахыг батлан дааж буй агуулгыг тусгасан байх)
2. Уригчийн гадаад иргэний оршин суух үнэмлэхийн хуулбар (2 тал)
3. Сургуулийн тодорхойлолт (Эсхүл ажлын газрын тодорхойлолт), Дүнгийн тодорхойлолт
4. Түрээсийн гэрээ (Нотариатаар баталгаажуулсан байх)
5. Дансны тодорхойлолт болон сүүлийн 3 сарын дансны хуулга

ø Анхаарах зүйлс

Гадаад иргэний оршин суух үнэмлэхийн хугацаа болон түрээсийн гэрээний хугацаа хамгийн багадаа 3 сараас дээш байх

Уригч талын холбогдох бичиг баримт эх хувиар байх